

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН
ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ГАЗРЫН 2019 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2019 оны 04 дүгээр сарын 25

Замын-Үүд сум

Тус газар нь Монгол улс, Олон улсын хэлэлцээр, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Боомтын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145, 339, 146 дугаар тогтоол, журам тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актууд, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын тушаал, албан даалгаврыг тус тус удирдлага болгон гадаадын иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилэхэд анхаарч 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1 Монгол Улсын виз, зөвшөөрөл, хяналт шалгалтын талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолыг тус тус үндэслэн виз хүссэн 3 орны 97 иргэнд зохих ангиллын визийг олгож, визийн хураамж болох 9,779,900.00 төгрөгийг Төрийн сангийн дансанд нь төвлөрүүлэн ажилласан. Үүнд:

- Нэг удаагийн орох – 77 иргэн
- Нэг удаагийн гарах-орох – 12 иргэн
- Хоёр удаагийн гарах-орох – 2 иргэн
- Визийн шилжүүлэг – 3 иргэн
- Олон удаагийн гарах-орох-2 иргэн
- Дамжин өнгөрөх -1 иргэн

1.2 Хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын иргэдийн талаар:

Хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын 1698 иргэн /давхардсан тоогоор/-ний хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавьж ажилласан.

1.3. Алдаатай визийн талаар:

Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаас алдаатай олгогдсон БНХАУ-ын 4 иргэний визийг илрүүлэн, холбогдох арга хэмжээг авч визийн засвар хийж хилээр нэвтрүүлсэн.

1.4 Түр ирэгч бүртгэлийн талаар:

БНХАУ-ын 47 иргэнийг түр ирэгчээр бүртгэн, бүртгэлийн хураамж болох 94000 төгрөгийг зохих дансанд төвлөрүүлсэн.

1.5. Хасалт хийсэн талаар:

Түр ирэгчийн хасалт хийлгэхийг хүссэн БНХАУ-ын 47 иргэн, Зөрчлийн тухай хууль зөрчсөн БНХАУ-ын 22 иргэнд хасалт хийсэн байна.

1.6. Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар:

БНХАУ-ын 113 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч, мэдээллийг Төвд хүргүүлж ажилласан.

1.7. Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар:

Тус газрын хяналтын улсын байцаагчид Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22.1.6-д заасны дагуу Монгол Улсад байх болон буцаж явах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй БНХАУ-ын 201 иргэнийг улсын хилээр нэвтрүүлэлгүй буцаан ажилласан.

1.8. Захиргааны арга хэмжээ авсан талаар:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн 2 орны 18 иргэнд 1,290,000.00 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Монгол Улсад хууль бусаар хөдөлмөр эрхэлсэн БНХАУ-ын 2 иргэнийг ГИЭЗБТх-ийн 37.1.7, Зөрчлийн тухай хуулийн 16.2-1.4-д зааснаар торгуулийн арга хэмжээ авч албадан гаргасан.

Тус газрын Сайншанд дахь мэргэжилтэн П.Гантулга, Говьсүмбэр аймаг дахь мэргэжилтэн Г.Төрболд нар Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны № 05 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрээн-Улаанбаатар, Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн нийтийн тээврийн автобусаар зорчиж буй гадаад иргэдийн хөдөлгөөнд 14 удаа хяналт шалгалт тавьж ажилласан байна.

Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн ДГ-2019/04 дугаар удирдамжын дагуу Хяналтын Улсын ахлах байцаагч Б.Баярхүү, хяналтын улсын байцаагч Б.Сүлд-Очир, мэргэжилтэн П.Гантулга нарын бүрэлдэхүүнтэйгээр 04 дүгээр сарын 22, 23-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрт ажиллаж байгаа гадаадын иргэдийн бичиг баримтанд төлөвлөгөөт хяналт, шалгалтыг явуулсан. Шалгалтаар нийт 10 аж ахуйн нэгж байгууллагын 27 иргэн хамрагдсан. Илэрсэн зөрчлийг илтгэх хуудсаар газрын дарга болон хяналт, шалгалтын газарт танилцуулан ажилласан.

Хоёр. Дотоод ажлын хүрээнд

2.1. Тушаал, тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн талаар:

Тайлант хугацаанд газрын дарга 2 тушаал гаргасан ба үндсэн үйл ажиллагааны талаарх хоногийн мэдээ, тус газрын үйл ажиллагааны тайланг гаргаж холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

2.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын талаар

Тайлант хугацаанд бусад байгууллагаас ирүүлсэн 21 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэлжүүлэн, хариутай 4 албан бичгийг хугацаанд өгч, 11 албан бичиг боловсруулжээ.

Албан хаагчдаас чөлөө хүссэн 6 өргөдөл хүлээн авч өргөдлийг шийдвэрлэн ажиллаа.

Тус газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн гомдол байхгүй болно.

2.3. Хүний нөөц, сургалтын талаар

Замын-Үүд сум дахь сум дундын цагдаагийн хэлтэстэй хамтран 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр “Хар тамхи сэтгэцэд нөлөөт бодис, түүний хор уршиг, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр сургалт зохион байгуулж сургалтанд нийт 14 албан хаагч хамрагдсан.

2.4. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар

2019 оны 03 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гарган ndaatgal.mn цахим сайтад шивж, 23 албан хаагчийн нийгмийн даатгалын дэвтэрт бичилт хийж, нийгмийн даатгалын тасгаар баталгаажуулсан.

“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган ажилласан талаар:

✓ Тухай бүрт нь оруулах мэдээлэл-8

✓ Сар бүр оруулах мэдээлэл-3 нийт 11 мэдээллийг хуулийн хугацаанд

шилэн дансны сайтад шивж байршуулсан.

Үнэт цаасны 03 дугаар сарын тайланг хяналтын улсын байцаагч нараас хүлээн авч хянан, 2019 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлсэн.

2019 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар Төв газар болон Дорноговь аймаг дахь газраас Замын-Үүд сумын Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн орлого:

/төгрөгөөр/

Замын-Үүд сумын Төрийн сангийн данс	Гадаадын иргэн харьяатын газар	Дорноговь аймаг дахь газар	Нийт дүн
Хүү торгуулийн орлого		1,536,000.00	
Улсын тэмдэгтийн хураамжийн орлого	89,812,400.00	100,000.00	91,348,400.00

Төв газрын дансанд 03 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар визийн хуудасны үнэ 224,000.00 төгрөгийг шилжүүлсэн байна.

2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд нийт 39,450,500.00 төгрөгийн санхүүжилт авч, зарлага 34,185,300.34 төгрөгийг Замын-Үүд төрийн сангаар хянуулан гүйлгээг хийсэн. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил- 27,066,900.00 төгрөг
- Нийгмийн даатгалын шимтгэл- 2,611,799.81 төгрөг
- ХХОАТ-1,603,701.95 төгрөг
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал- 4,104,800.00 төгрөг
- Тээвэр шатахууны зардал- 1,580,000.00 төгрөг
- Шуудан холбоо интернетийн зардал-795,885.00 төгрөг
- Ном хэвлэл-130,000.00 төгрөг
- Бага үнэтэй түргэн элэгдэх материалын зардал-320,000.00 төгрөг
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал-100,000.00 төгрөг

2019 оны 03 дугаар сарын няравын тайланг хүлээн авч орлого зарлагын гүйлгээг хянан баталгаажуулсан.

Засвар үйлчилгээний талаар:

Тус газрын 301 тоот өрөөнд тааз, хана, цонх, паарны будгийн ажлыг хийж, гадна дотор 2 хаалга, ариун цэврийн өрөөнд ОО-н суултуур, бойлуурыг шинээр суурьлуулж, сантехникийн холболтыг бүрэн хийж дуусгасан.



Байгууллагын гадна талын төмөр хашаа, хайс, автомашины зогсоолын тэмдэг тэмдэглэгээ, гражны хаалганы анхааруулга тэмдгийг будаж засварлалаа.



2.4. Мэдээллийн технологийн чиглэлээр

Тайлант хугацаанд газрын хэмжээнд мэдээлэл технологийн ажлын хэвийн үйл ажиллагааг хангаж, эрхэлсэн ажлын хүрээнд удирдлагыг мэдээллээр ханган, нийт 10 удаагийн дуудлага хүлээн авч албан хаагчдын компьютер, техник хэрэгсэлд шаардлагатай үйлчилгээг хийсэн.

Гурав. Бусад

Дорноговь аймгийн “Хууль сахиулах чиг үүргийн байгууллагын Төрийн албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөн” Сайншанд суманд 2019 оны 04 дүгээр сарын 04, 05-ны өдрүүдэд зохион байгуулагдаж уг зөвлөгөөнд Хяналтын улсын байцаагч Б.Хадбаатар, мэргэжилтэн Г.Буянням, Т.Мягмардорж, П.Гантулга, Г.Төрболд нар хамрагдлаа.

Сайншанд дахь төлөөллийн албны өрөөнд 2019 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр 70520006 дугаартай телефон утсыг шинээр холбуулсан.

Байгууллагын даргын 2019 оны Б/95 тоот тушаалын дагуу төв газарт 2019 оны 04 дүгээр сарын 12,13,14-ны өдрүүдэд Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх, төрийн байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт, ажилтнуудын баримт бичигтэй ажиллах чадамжийг дээшлүүлэх талаар захиргааны албан хаагчдын сургалт зохион байгуулагдаж сургалтанд захиргааны ахлах мэргэжилтэн Б.Энхчимэг хамрагдлаа.

Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч Ж.Хунан 2019 оны 04 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд суманд ажиллаж хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдад гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хийлээ.

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2019 оны Б/105 дугаар тушаалаар тус газарт захиргааны ахлах мэргэжилтнээр Б.Энхчимэг томилогдсон.

Монгол Улс БНХАУ дипломат харилцаа тогтоосон 70 жилийн ой, Монгол Улсын Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Дотоодыг хамгаалах товчоо хоорондын хамтран ажиллах протоколд гарын үсэг үзгэлсний 1 жилийн ойг тохиолдуулан хоёр талын албан хаагчдын спортын нөхөрсөг тэмцээн 2019 оны 04 дүгээр сарын 18, 20-ны өдрүүдэд БНХАУ-ын Эрээн хотод зохион байгуулагдаж баг тамирчид амжилттай оролцлоо.

